# МОНГОЛ УЛС
# ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр　　　　Дугаар А/13　　　　Хэрлэн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын 2009 оны 348 дугаар тогтоол болон "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан 4 төрийн байгууллагуудад 1 дүгээр хавсралтад заагдсан газрыг эзэмшүүлсүгэй.

2. Төрийн байгууллагуудын газрын эзэмшиж байгаа газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг хавсралтад дурдсан байгууллагуудад даалгасугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны А/258 дугаар захирамжийн 6, 7, 2016 оны А/194 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА　　　　Н.ГАНБЯМБА

D:\My Documents\Захирамж 2019.doc

Аймгийн Засаг даргын 2019 оны
..01.. дүгээр сарын...11...өдрийн ...А/13...
дугаар захирамжийн хавсралт

## ХЭРЛЭН СУМАНД ГАЗАР ЭЗЭМШИЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ

| д/д | Иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр | Регистрийн дугаар | Хуучин талбайн хэмжээ /м$^2$/ | Талбайн хэмжээ /м$^2$/ | Байршил | Газар эзэмшлийн зориулалт | Хугацаа /жил/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ | 2685221 | 8706 | 19655 | 3-р баг | Төрийн байгууллага | 54 |
| 2 | Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн төв | 9073752 | 1045 | 1504 | 3-р баг Залуучуудын гудамж | Төрийн байгууллага | 24 |
| 3 | Хан хэнтий чуулга | 4185676 | 2700 | 2664 | 3-р баг Залуучуудын гудамж | Төрийн байгууллага | 23 |
| 4 | Нэгдсэн эмнэлэг | 9076263 | 28200 | 32619 | 4-р баг Навааннэрэн гудамж | Төрийн байгууллага | 45 |